

“ТАВАНТОЛГОЙ ТҮЛШ” ХХК

ТӨМӨР ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер
шалгаруулалтын
нэр:

ТӨМӨР ХУДАЛДАН АВАХ

Тендер
шалгаруулалтын
дугаар:

ТТТХХК20240102226

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ).....	1
1. Тендерийн цар хүрээ	1
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг	1
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж.....	1
4. Сонирхогч этгээд, оролцогч	2
5. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ.....	2
6. Нийлүүлэх барааны гарал үүсэл	2
7. Тендер шалгаруулалтын баримт бичиг	2
8. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах	3
9. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт	3
10. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл.....	3
11. Тендерийн иж бүрдэл	4
12. Тендерийн жишиг маягтууд.....	4
13. Хувилбарт санал	4
14. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг.....	5
15. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг	5
16. Чадавхын болон туршлагын шаардлага.....	6
17. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт	7
18. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт.....	7
19. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт	7
20. Тендерийн валют	8
21. Тендер хүчинтэй байх хугацаа	8
22. Тендерийн баталгаа	9
23. Тендер баталгаажуулах, илгээх	9
24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа	10
25. Тендерийн талаар тодруулга авах.....	10
26. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх.....	10
27. Тендерийг үнэлэх	10
28. Арифметик алдааг залруулах.....	10
29. Оролцогчид давуу эрх олгох.....	10
30. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт	10
31. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох	10
32. Тендерийг эрэмбэлэх	11
33. Оролцогчийн чадавхыг дахин магадлах.....	11
34. Мэдэгдэл хүргүүлэх.....	11
35. Гүйцэтгэлийн баталгаа	11
36. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах	11

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Тендерийн цар хүрээ
 - 1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “**Хууль**” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “**бараа**” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.
 - 1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.
 - 1.3. Барааг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой багцын барааг хуулийн 8.1-д зааснаар дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой бол энэ тухай захиалагч өгөгдлийн хүснэгтэд заана. Ийнхүү заасан бол тендер шалгаруулалт, эсхүл түүний багцад зөвхөн Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлнэ.
 - 1.4. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгт болон зарлалд заана.
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг
 - 2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж
 - 3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
4. Худалдан авах ажиллагааны цахим систем
 - 4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.
5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх
 - 5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.
 - 5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад

- оролцох эрхгүй байна.
- 6. Сонирхогч оролцогч этгээд,**
- 6.1. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.
- 6.2. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.
- 6.3. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.
- 6.4. Тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т заасан үйлчилгээний хураамж төлсөн байна.
- 6.5. ТШЗ-ны 6.4-т заасан үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.
- 7. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ**
- 7.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.
- 7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.
- 7.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.
- 7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.
- 7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 8. Нийлүүлэх барааны гарал үүсэл**
- 8.1. ТШЗ-ны 1.3-т өөрөөр заагаагүй бол гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.
- 9. Тендер шалгаруулалтын баримт бичиг**
- Б.АГУУЛГА**
- 9.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:
- I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;
 - II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;
 - III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;
 - IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;
 - V Бүлэг. Тендерийн жишиг маягт;
 - VI Бүлэг. Гэрээний нөхцөл.
- 9.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер

шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

9.3. Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн тендер бэлтгэнэ.

10. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах

10.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтийг хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар захиалагчид гаргах бол Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүргүүлнэ.

10.2. ТШЗ 10.1-д заасан хүсэлтэд ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд болохыг нотлох баримтыг хавсаргана.

10.3. Тодруулгын дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл захиалагч хуулийн 20.6-д заасны дагуу шийдвэрлэнэ.

11. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт

11.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана. Захиалагч уулзалтад ТШЗ-ны 6.6-д заасан сонирхогч этгээд, түүний төлөөллийг оролцуулна.

11.2. ТШЗ-ны 11.1-д заасан уулзалтад оролцоогүй нь аж ахуй эрхлэгчийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн ТШЗ-ны 12.1-д заасан хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн хэл болон гадаад хэлээрх хувилбар хоорондоо зөрвөл ТШЗ-ны 12.1-д заасан хэлээр бэлтгэсэн тендер шалгаруулалтын баримт бичгийг баримтална.

12.4. Захиалагч ТШЗ-ны 12.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөрөө

орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

- 13. Тендерийн иж бүрдэл**
- 13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн бараа нийлүүлэх техникийн болон үнийн санал байна.
- 13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:
- 13.2.1. ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэсэн маягтууд;
- 13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;
- 13.2.3. захиалагч зөвшөөрсөн бол ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;
- 13.2.4. оролцогч ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;
- 13.2.5. санал болгож буй бараа ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;
- 13.2.6. бараа нийлүүлэлтийн хуваарь;
- 13.2.7. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 18, ТШЗ 19, ТШЗ 20 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;
- 13.2.8. ТШЗ-ны 21 дүгээр зүйлд заасан барааны үнийн задаргаа;
- 13.2.9. ТШЗ-ны 21.9-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;
- 13.2.10. түншлэл бол хуулийн 6.3-т заасан түншлэлийн гэрээ.
- 13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.
- 13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.
- 14. Тендерийн жишиг маягтууд**
- 14.1. Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтын дагуу илгээнэ.
- 15. Хувилбарт санал**
- 15.1. Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан заасан тохиолдолд оролцогч хуулийн 11.10-т заасанд нийцэх хувилбарт саналыг тендерт ирүүлж

болно.

- 16. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг**
- 16.1. Оролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.
- 16.2. Монгол Улсын хуулийн этгээд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ.
- 16.3. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:
- 16.3.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;
- 16.3.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;
- 16.3.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.
- 16.4. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 14.2, 14.3-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.
- 17. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг**
- 17.1. Нийлүүлэхээр санал болгох барааны гарал үүслийн мэдээллийг V бүлгийн Маягт 2-ын холбогдох хэсэгт бөглөж ирүүлнэ.
- 17.2. Хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй.
- 17.3. Оролцогчийн санал болгож буй бараа нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлох баримтыг өгөгдлийн хүснэгтэд зааснаар тендерт ирүүлнэ.
- 17.4. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол оролцогч өөрийн санал болгож байгаа бараанд холбогдох загвар, дээжийг тендер нээх эцсийн хугацаанаас өмнө захиалагчид хүргүүлэх ба шалгалт, туршилтыг хийх ажиллагаанд оролцогчийг өгөгдлийн хүснэгтэд зааснаар оролцуулна.
- 17.5. Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно. Санал болгох бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэнийг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг техникийн

тодорхойлолттой нийцсэн болохыг хянан үзэх боломжтой баримт, хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарласан тайлбар ирүүлсэн байна.

- 17.6. Барааг нийлүүлснээс хойш өгөгдлийн хүснэгтэд заасан хугацааны туршид тасралтгүй, горимын дагуу ашиглахад шаардагдах өгөгдлийн хүснэгтэд заасан сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалтыг тэдгээрийг авах боломжтой хаяг, үнийн мэдээллийн хамт ирүүлнэ.
- 17.7. Техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал, тоног төхөөрөмжийн загвар, хэмжих нэгж, стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар зэрэг нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.
- 17.8. Гадаадын этгээдийн хувьд гэрээний дагуу хийгдэх техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлөгч гүйцэтгэх тухай баримт;
- 17.9. Монгол Улсын гарал үүсэлтэй бус бараа нийлүүлэхээр санал болгосон оролцогч нь техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээлэл;
- 17.10. Хуулийн 8.4-т зааснаар давуу эрх тооцуулах барааны Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлснээр Сангийн сайдын баталсан Давуу эрх олгох аргачлал, зааврын дагуу тооцно. Барааны үнийн задаргаанд Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг заагаагүй, эсхүл гарал үүслийг нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх тооцохгүй.
- 17.11. ТШЗ-ны 1.3-т зааснаар нийлүүлэхээр санал болгох бараа Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Нотлох баримт бичиг ирүүлээгүй тохиолдолд тухайн барааг шаардлага хангаагүй гэж үзнэ.
- 17.12. Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс нийлүүлэхээр санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

18. Чадавхын туршлагын шаардлага

- болон** 18.1. Захиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн хүснэгтэд заах ба хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална.

- 18.2. Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана. Тухайн бараа, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг захиалагч шаардсан бол түншлэлийн гишүүн тус бүр уг шаардлагыг хангасан байх шаардлагатай. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.
- 18.3. Түншлэл нь ТШЗ-ны 18.1-д заасан доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. Борлуулалтын орлогын хэмжээ, ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг ТШЗ-ны 18.1-д заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
- 18.4. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

19. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт

- 19.1. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 19.2. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.
- 19.3. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

20. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт

- 20.1. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.

21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт

- 21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад

нийцсэн байна.

- 21.2. Барааны үнийн задаргаанд багц тус бүрийн барааны нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг тусгаж ирүүлнэ.
- 21.3. Оролцогч үнийн хөнгөлөлт санал болгох бол ТШЗ-ны 14-т заасан тендер илгээх маягтад заана.
- 21.4. ТШЗ 21.3-т зааснаар үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг тендерийн үнэ гэж үзнэ.
- 21.5. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.
- 21.6. Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
- 21.7. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
- 21.8. ТШЗ-ны 21.2-т заасан барааны үнийн задаргааны нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч тендер илгээх маягтад үнээс зөрүүтэй бол барааны үнийн задаргааны нийт нийлбэрийг тендер илгээх маягтын үнэ гэж үзнэ.
- 21.9. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

22. Тендерийн валют

- 22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

23. Тендер хүчинтэй байх хугацаа

- 23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.

23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

24. Тендерийн баталгаа

24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрээр ТШЗ-ны 24.1-д зааснаар ирүүлнэ.

24.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

25. Тендер баталгаажуулах, илгээх

25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 6-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

- 26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа** 26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.
- 26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

- 27. Тендерийн талаар тодруулга авах** 27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.
- 28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх** 28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасан иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн хянан үзнэ.
- 29. Тендерийг үнэлэх** 29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.
- 29.2. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.
- 30. Арифметик алдааг залруулах** 30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.
- 30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.
- 31. Давуу эрх олгох** 31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн дотоодын бараанд хуулийн 8.4-т зааснаар давуу эрх олгож, дотоодын барааны хэсгийн үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.
- 31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.
- 31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.
- 32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт** 32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
- 33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох** 33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална.

- 33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ.
- 33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
- 34. Тендерийг эрэмбэлэх** 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.
- 35. Оролцогчийн чадавхыг магадлах дахин** 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадална.
- 35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 19 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 20 дугаар зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.
- 35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

- 36. Шийдвэр хүргүүлэх** 36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.
- 37. Гүйцэтгэлийн баталгаа** 37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
- 37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
- 38. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах** 38.1. Захиалагч ТШЗ-ны 9.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.
- 38.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ӨХ)

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: “Тавантолгой түлш” ХХК
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: “Төмөр худалдан авах”
ТШЗ 1.1	Тендерийн урилгын дугаар: “ТТТХХК20240102226”
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: “Багцгүй”
ТШЗ 1.4	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “Үгүй”
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: “Өөрийн хөрөнгөөр”
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 1,403,863,800 (Нэг тэрбум дөрвөн зуун гурван сая найман зуун жаран гурван мянга найман зуу) төгрөг
Б. АГУУЛГА	
ТШЗ 8.1	Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг: Хаяг: Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р баг, Баянбүрд, Баян уулын баруун талд 0 тоот Утасны дугаар: 70119400 Цахим шуудангийн хаяг: <u>info@ttt.mn</u>
ТШЗ 11.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “Үгүй”
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.2	Тендер шалгаруулалтын хэл: “Монгол хэл”
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: “Зөвшөөрөхгүй”
ТШЗ 16.1.2	Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: “Шаардана” <i>Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу өр төлбөр төлүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа, эсхүл татварын, эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй бол ерөнхий шаардлага хангахгүй гэж үзнэ.</i> <i>Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн, өр төлбөргүй байх шаардлагатай. Нийгмийн даатгал, татварын тодорхойлолтыг ирүүлэхдээ “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” www.tender.gov.mn болон “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий</i>

	<p><i>газрын цахим мэдээллийн сангаас шалгана.</i></p> <p><i>Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолтыг цахим системээр ирүүлнэ: Тендер оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлт хийхээс 3-аас доошгүй хоногийн өмнө нэвтрэн орж шүүхийн тусгай архивын лавлагаа авах хүсэлтийг илгээх бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл хянан үзэж лавлагаа цахимаар илгээдэг болохыг анхаарна уу.</i></p> <p><i>Шүүхийн тусгай архивын лавлагааг цахим хэлбэрээр авна.</i></p> <p><i>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт авах хүсэлтийг тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлтээс өмнө хүчин төгөлдөр тодорхойлолтыг цахим хэлбэрээр ирүүлнэ.</i></p> <p><i>Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх шаардлагагүй бөгөөд "Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем"-ээр дамжуулан шалгана.</i></p>
ТШЗ 17.4	Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж ирүүлэх эсэх: "Үгүй"
ТШЗ 17.6	Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх эсэх, ирүүлэх бол хугацаа: "Үгүй"
ТШЗ 18.1	<p>Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн шаардлага, шалгуур үзүүлэлт: "Шаардахгүй"</p> <p>Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: "Шаардана"</p> <ol style="list-style-type: none"> <i>Батлагдсан төсөвт өртгийн 80 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй барааг 2022, 2023 онуудын аль нэг жилд 1 удаа нийлүүлсэн гэрээ байх.</i> <i>Ижил төстэй бараа гэдэгт Төрөл бүрийн төмөр, төмөр эдлэл нийлүүлсэн туршлагатай байх.</i> <i>Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний талаар мэдээллийг V бүлгийн Маягт 3, 5-ын дагуу бэлтгэн ирүүлэх</i> <p>Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шаардлага: "Шаардахгүй"</p>
ТШЗ 18.2	Тусгай зөвшөөрөл: "Шаардахгүй"
ТШЗ 19.1	<p>Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: "Тийм"</p> <ol style="list-style-type: none"> <i>Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс тендер шалгаруулалт зарласан өдрөөс хойш авсан, шалгах боломжтой QR код бүхий "Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт"-ыг ирүүлнэ. Уг тодорхойлолтод төлөгдөж дуусаагүй зээлийн мэдээлэл "Хэвийн" бус</i>

	<p>байгаа тохиолдолд татгалзах үндэслэл болно. (“Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг www.sainscore.mn, www.burenscore.mn хаягаар хандан авна.</p> <p>2. Санхүүгийн тайланд аудит хийлгэх үүрэгтэй оролцогчийн хувьд аудитын дүгнэлтийг 2022, 2023 он тус бүрээр хавсарган ирүүлэх ба ирүүлээгүй нь татгалзах үндэслэл болно.</p> <p>3. Сүүлийн 2 жил буюу 2022, 2023 оны аль нэг жилийн борлуулалтын орлого төсөвт өртгийн 80 хувиас багагүй байх.</p> <p>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой дүн төсөвт өргийн 50%-с багагүй байх ба дараах шалгуур үзүүлэлтүүдийг аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр нь тодорхойлно. Үүнд:</p> <p>1.1. Байгууллагын харилцагч банкна дахь харилцах дансны үлдэгдлийн баталгаа,</p> <p>4. 1.2. Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий судлагдсан зээлийн тодорхойлолт, /төсөвт өртгийн 50%-аас багагүй байна/</p>
<p>ТШЗ 20.1</p>	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэх эсэх: “Туйм”</p> <ol style="list-style-type: none"> 1. Оролцогч өөрөө үйлдвэрлээгүй барааг нийлүүлэхээр санал болгох тохиолдолд уг барааг нийлүүлэх боломжтой болохыг нотлох нийлүүлэгч, үйлдвэрлэгчтэй байгуулсан гэрээ, эсхүл тэдгээрээс энэ тухай гаргасан үйлдвэрлэгчийн албан ёсны борлуулагч эсвэл итгэмжлэл ирүүлэх. 2. Барааны үнийн задаргаа баталгаажуулж ирүүлэх. 3. Гэрээний үүргийн гүйцэтгэлийг хариуцах ажилтны нэр, боловсрол, харилцах мэдээллийг нэгтгэн ирүүлэх. 4. Оролцогчийн ерөнхий шаардлагыг магадлах ба V бүлгийн Маягт 1-ийн дагуу бэлтгэн ирүүлнэ. 5. Бараа нийлүүлсэн туршлага 2 жилийн (2022, 2023 он) (Сүүлийн 2 жилийн аль нэг жилд батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 80%-иас багагүй хэмжээний Төрөл бүрийн төмөр нийлүүлэх ажлыг 1 удаа гүйцэтгэсэн байх). Гэрээ, гэрээ дүгнэсэн акт ирүүлнэ. 6. Захиалагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг харьцуулсан байдлаар хүснэгтээр бэлтгэн зүйл заалт бүрээр нийцсэн тайлбар ирүүлнэ. 7. Чанарын шаардлага хангаагүй бараа бүтээгдэхүүнийг нөхөн өөрийн зардлаар сольж өгөх мэдээгдэл ирүүлэх. 8. Гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байгаа талаар албан мэдээгдэл ирүүлнэ. <p>Оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: “Шаардахгүй”</p> <p>Оролцогч нь өөрийн болон түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээллийг V бүлгийн Маягт 4-ын дагуу ирүүлнэ.</p>
<p>ТШЗ 21.5.</p>	<p>Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулахгүй тогтмол байна”</p>

ТШЗ 21.6	Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: “Туйм” <i>Incoterms 2020, Delivery Duty Paid (DDP)</i> “Тавантолгой түлш” ХХК-ийн Зүүн үйлдвэр, Баруун үйлдвэр, Төвийн үйлдвэрийн агуулах хүргэж өгч буулгах
ТШЗ 24.1	Тендерийн баталгааны дүн: Төсөвт өртгийн 0,5 хувиар тооцон ирүүлнэ.
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 25.5.	Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: 1. Оролцогчийн ерөнхий шаардлагыг магадлах нотлох баримт бичиг 2. Үйлдвэрлэгч, борлуулагчтай хиисэн гэрээ эсхүл албан бичиг 3. Тендер шалгаруулалтын баримт бичигт тусгасан маягтын дагуу илгээсэн мэдээлэлүүд 4. Хуулийн 22.5-д заасан үндэслэлээр ил болгохгүй мэдээлэл баримт бичиг, мэдээлэл байгаа бол түүний хууль зүйн үндэслэлийг тайлбарласан мэдэгдэл
ТШЗ 26.1.	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2024 оны 04-р сарын 22-ны өдөр Цаг: 10 цаг 00 минут
ТШЗ 26.2.	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2024 оны 04-р сарын 22-ны өдөр Цаг: 10 цаг 30 минут Тендер нээх газрын хаяг: Төв аймаг, Сэргэлэн сум 1-р баг, Баянбүрд, Баян уулын баруун тал, Зүүн үйлдвэр А байрны 231 тоот
Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ	
ТШЗ 29.2.	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: “Үгүй”
ТШЗ 31.1.	Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг: Шаардахгүй “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 8-р зүйлийн 8.4-т заасан нөхцөлийн аль нэгийг хангасан тохиолдолд тооцно.
ТШЗ 32.1	Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: “Ашиглахгүй”

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Бараа материалын нэр: Төвийн үйлдвэрийн төмөр худалдан авах

№	Техникийн өгөгдөл	Үзүүлэлт	Тоо ширхэг	Нэмэлт шаардлага	Дүйцүүлэх нэршил	Хавсралт зургын дугаар
1	Двухтавр	200x200x10мм	120м			Зураг1
2	Квадрат	50*70*4мм	120м			Зураг2
3	Квадрат	100*100*4мм	180м			Зураг3
4	лист	Лист хар 20мм 1.5*6м	80м/кв			Зураг4
5	Полса	10*10мм	80м			Зураг5
6	Угольник	Хар 100*10	84м			Зураг6
7	Швеллер	160*5мм	240м			Зураг7
8	Швеллер	120*4мм	120м			Зураг8
9	Швеллер	140*5мм	240м			Зураг9
10	Квадрат 100*100*4	100*100*4	40м			Зураг10
11	Квадрат 100*100*4	100*100*4	120м			Зураг11
12	Квадрат 40*40*1,5	40*40*1,5	200м			Зураг12
13	Квадрат 50*50*4	50*50*4	378м			Зураг13
14	Квадрат 70*70*3	70*70*3	200м			Зураг14
15	Круг 10	ф10мм	200м			Зураг15
16	Круг 12	ф12мм	500м			Зураг16
17	Круг 16	ф16мм	500м			Зураг17
18	Лист 10мм	10мм	110м/кв			Зураг18
19	лист 20	20мм	25м/кв			Зураг19
20	лист 2мм	2мм	4м/кв			Зураг20

21	Лист 4	40мм	36м/кв			Зураг21
22	Лист 6	60мм	234м/кв			Зураг22
23	Лист нерж нүхгүй	3мм	80м/кв			Зураг23
24	Полоса	100x10	240м			Зураг24
25	Полоса 50*3мм	50*3мм	350м			Зураг25
26	Угольник 100	100x100x8	36м			Зураг26
27	Угольник	50x50x2.5	300м			Зураг27
28	Угольник 50*3	50*3	448м			Зураг28
29	угольник 50*4	50x50x40	240м			Зураг29
30	ф25 цайрдсан төмөр труба	ф25	60м			Зураг30
31	Хар труба 100*5	100*5	144м			Зураг31
32	Хар Труба 25	ф25мм 2.5мм зузаан	480м			Зураг32
33	Хар Труба 32	ф-32 уурын 250°С ажиллах цутгамал	60м			Зураг33
34	Хар труба 32 3,5	32*3.5	150м			Зураг34
35	Хар труба 50 4,0	50*4.0	150м			Зураг35
36	хар труба 89*5	89*5	150м			Зураг36
37	Цагаан труба	ф40x3 цайрдсан	480м			Зураг37
38	Цагаан труба	ф20	60м			Зураг38
39	Цагаан труба 32	ф32	60м			Зураг39
40	Швеллер 10*4,8	10*4,8	120м			Зураг40
41	Швеллер 120	120мм	120м			Зураг41
42	Швеллер 14	140мм	240м			Зураг42
43	Швеллер 16	160мм	240м			Зураг43

44	Шигшүүрийн тор	12x12 4.1x1.65м утасны диаметр ф2мм	3 ш			Зураг44
45	Шигшүүрийн тор 0,5*0,5	0.5*0.5 4.1x1.65м утасны диаметр ф2мм	3 ш			Зураг45
46	Шигшүүрийн тор 20*20	20*20 4.1x1.65м утасны диаметр ф3мм	3 ш			Зураг46
47	Уголник 50*3мм	50*3мм	200м			Зураг47

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Бараа материал: Баруун үйлдвэр төмөр худалдан авах

Баруун үйлдвэр багаж худалдан авах			Хэмжих нэгж	Тоо ширхэг	Зураг
Д/Д	Нэршил	Техникийн тодорхойлолт			
1	Угольник140	L-6 140*100мм*7мм	Метр	100	Зураг-1
2	Швеллер 14	Швеллер с140х55мм	Метр	150	Зураг-2
3	Угольник 120	Урт 6м 120мм*100мм зузаан 7мм буюу түүнээс дээш	Метр	100	Зураг-3
4	Угольник 100*100	100*100*6мм L=6м	Метр	100	Зураг-4
5	Швеллер 120*55мм	C120х55мм L=6м	Метр	100	Зураг-5
6	Швеллер 160*6	C160х55мм L=6м	Метр	60	Зураг-6
7	Лист 2мм	2мм зузаан	Метр квадрат	60	Зураг-7
8	Турба	L-6 ф32*3.5 Q345	Метр	200	Зураг-8
9	Угольник 70	L-6 70*70мм*5мм	Метр	100	Зураг-9
10	Швеллер 8*5	C80х50мм L=6м Q345	Метр	100	Зураг-10
11	Полоса 8*6	Өргөн 80мм*зуз 6мм Q345 L6м	Метр	200	Зураг-11
12	Круг ф25	Ф-25мм Q-345	Метр	200	Зураг-12
13	Швеллер 5*5	C50х3,5*5мм L=6м	Метр	100	Зураг-13
14	Лист 3мм	Хээтэй ,зузаан 3 мм , 1,5м*6м	Метр квадрат	27	Зураг-14
15	Лист 5	Зузаан 5мм , 1,5м*6м	Метр квадрат	9	Зураг-15
16	Лист 4 1,5*6	Зузаан 4мм 1,5м*6м	Метр квадрат	9	Зураг-16
17	Угольник 50*4	50мм*50мм зузаан 4мм	Метр	100	Зураг-17
18	Квадрат төмөр 100*100*4	Квадрат төмөр 100*100*4мм 6м урт	Метр	150	Зураг-18
19	Квадрат төмөр	Квадрат төмөр 80*80*3мм	Метр	180	Зураг-19

	80*80*3	хэмжээтэй 6м урт			
20	Квадрат төмөр 100*100*2	Квадрат төмөр 100*100*2мм 6м урт	Метр	90	Зураг-20
21	Квадрат төмөр 50*50*3	Квадрат төмөр 50*50*3мм хэмжээтэй 6м урт	Метр	90	Зураг-21
22	Полоса 6	6см өргөн 4мм зузаан L-6м	Метр	130	Зураг-22
23	Лист	6000*1500*8мм	Метр квадрат	45	Зураг-23
24	Угольник	70*70*5мм	Метр	180	Зураг-24
25	Лист	6000*1500*5мм	Метр квадрат	36	Зураг-25
26	Лист	6000*1500*16мм	Метр квадрат	11	Зураг-26
27	Лист	6000*1500*3мм	Метр квадрат	45	Зураг-27
28	Угольник	50*50*4мм	Метр	180	Зураг-28
29	Ган хар труба	Ф20мм-н хананы зузаан 3мм	Метр	240	Зураг-29
30	Ган хар труба	Ф25мм-н хананы зузаан 3мм	Метр	240	Зураг-30
31	Цайрдсан цагаан ган труба	Ф50мм-н хананы зузаан 4мм	Метр	240	Зураг-31
32	Ган хар труба	Ф50мм-н хананы зузаан 4мм	Метр	240	Зураг-32
33	Ган хар труба	Ф32мм-н хананы зузаан 3.5мм	Метр	240	Зураг-33
34	Цайрдсан цагаан ган труба	Ф32мм-н хананы зузаан 3.5мм	Метр	240	Зураг-34
35	Цайрдсан цагаан ган труба	Ф40мм-н хананы зузаан 3.5мм	Метр	240	Зураг-35
36	Ган хар труба	Ф76мм-н хананы зузаан 4мм	Метр	150	Зураг-36
37	Ган хар труба	Ф40мм-н хананы зузаан 3.5мм	Метр	240	Зураг-37
38	Цайрдсан цагаан ган труба	Ф100мм-н хананы зузаан 4.5мм	Метр	150	Зураг-38
39	Швеллер төмөр	6.3*4.2	Метр	100	Зураг-39
40	Угольник хар төмөр	50*5мм	Метр	100	Зураг-40
41	Цайрдсан нимгэн төмөр	0.8мм зузаантай цайрдсан нимгэн төмөр	Метр квадрат	150	Зураг-41
42	Угольник хар төмөр	70*7мм	Метр	80	Зураг-42
43	Лист 20мм	Q345 20мм	Метр квадрат	9	Зураг-43

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Бараа материалын нэр: **Зүүн үйлдвэр төмөр худалдан авах**

№	Техникийн өгөгдөл	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Дүйцүүлэх нэршил	Хавсралт зургын дугаар
1	Цайрдсан труба ф25	ф25*3мм L=6 м	м	240	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 1
2	Цайрдсан труба ф32	ф32*3мм L=6 м	м	240	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 2
3	Цайрдсан труба ф50	ф50*3мм L=6 м	м	480	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 3
4	Цайрдсан труба ф76	ф76*3мм L=6м	м	480	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 4
5	ф100 цагаан труба	ф100*5мм L=6м	м	100	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 5
6	ф273 дулааны шугамын труба /өгөх, буцах/	ф273*8мм L=6м хар труба	м	30	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 6
7	Труба хар ф15	ф15*3мм L=6м	м	240	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 7
8	Труба хар ф20	ф20*3мм L=6м	м	420	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 8
9	Труба хар ф25	ф25*3мм L=6м	м	240	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 9
10	Труба хар ф32	ф32*3мм L=6м	м	480	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 10
11	Труба хар ф40	ф40*3мм L=6м	м	240	БНХАУ-н төмрийн стандартад	Зураг 11

					дүйцэхүйц	
12	Труба хар φ50	φ50*3мм L=6м	м	360	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 12
13	Труба хар φ100	φ100*3мм L=6м	м	240	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 13
14	Труба хар φ125	φ100*3мм L=6м	м	480	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 14
15	Труба хар φ150	φ100*3мм L=6м	м	480	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 15
16	Хар труба	φ25*3мм L=6м	м	278	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 16
17	Хар труба	φ80*3мм L=6м	м	200	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 17
18	Хар труба	φ60*3мм L=6м	м	150	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 18
19	Труба хар	φ80*3мм L=6м	м	100	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 19
20	Труба хар	φ20*3мм L=6м	м	560	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 20
21	Труба хар φ25	φ25*3мм L=6м	м	438	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 21
22	Турба хар	φ60*3 L=6м	м	420	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 22

23	Квадрат L=6м 100x100 мм	100x100мм хэмжээтэй 3мм зузаан ханатай	м	540	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 23
24	Квадрат L=6м 25x50 мм	25x50мм хэмжээтэй 3 мм зузаан ханатай	м	240	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 24
25	Квадрат L=6м 50x50 мм	50x50мм хэмжээтэй 3 мм зузаан ханатай	м	620	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 25
26	Квадрат L=6м 15x15 мм	15x15мм хэмжээтэй 1.5 мм зузаан ханатай	м	240	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 26
27	Квадрат L=6м 100x100 мм	Квадрат L=6м 100x100 мм	м	400	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 27
28	Квадрат L=6м 50x50 мм	Квадрат L=6м 50x50 мм	м	1,280	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 28
29	Квадрат L=4м 40x40 мм	Квадрат L=4м 40x40 мм	м	250	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 29
30	Квадрат L=4м 100x100 мм	Квадрат L=4м 100x100 мм	м	250	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 30
31	Швеллер 10x6	Швеллер С10x55мм L=6м	м	200	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 31
32	Швеллер	Швеллер С80x50мм L=6м	м	250	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 32
33	Швеллер 140*65мм	Швеллер 140x65мм L-6м	м	450	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 33
34	Швеллер 140*65мм	Швеллер С140x65мм L=6м	м	450	БНХАУ-н төмрийн	Зураг 34

					стандартад дүйцэхүйц	
35	Швеллер 120*55мм	Швеллер 120*55мм L-6м	м	200	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 35
36	Швеллер 120*55мм	Швеллер 120*55мм L-6м	м	810	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 36
37	Швеллер	Швеллер 10х4,8мм L-6м	м	648	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 37
38	Швеллер	Швеллер С140х55мм	м	540	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 38
39	Швеллер С160х55мм	Швеллер С160х55мм	м	100	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 39
40	Швеллер	Швеллер С120х55мм L=6м	м	2400	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 40
41	Угольник 40х4	Угольник 40*4мм L=6м	м	110	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 41
42	Угольник 40х4	40*5мм L=6м	м	300	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 42
43	Угольник 35х5	35*5мм L=6м	м	512	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 43
44	Угольник 20х5	20*5мм L=6м	м	200	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 44
45	Угольник хар 50*4мм L=6	Угольник хар 50*4мм L=6	м	300	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 45

46	Угольник 40x5мм L=6м	40x5мм L=6м	м	60	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 46
47	Лист 10мм	Лист Н=10мм ,L=6м	м2	18	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 47
48	Лист 2мм	б=2мм Н=2,L=6м	м2	565	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 48
49	Лист б=5мм Н=2,L=6м	б=5мм Н=2,L=6м	м2	12	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 49
50	Хээтэй лист Н=3,L=6м	Хээтэй лист Н=3мм, L=6м	м2	285	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 50
51	Круг ф50 L9 мм	Круг ф50 L9 мм	м	1130	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 51
52	Круг ф20 L9 мм	Круг ф20 L9 мм	м	700	БНХАУ-н төмрийн стандартад дүйцэхүйц	Зураг 52
